

## Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль 2022 оны 7 сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлнэ.

### Холбоо барих:

#### Майкл Ахэрн

Партнер  
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
michael.ahern@pwc.com

#### Чойжамцын Цэндмаа

Захирал  
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
tsendmaa.choijamts@pwc.com

#### Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний Менежер  
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

#### Батчулууны Амаржаргал

Ахлах хуульч  
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
amarjargal.batchuluun@pwc.com

#### Өмгөөллийн

#### ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар  
603 тоот, Улаанбаатар  
14200, Монгол улс  
Утас : + 976 70009089  
Факс : +976 11 322068  
[www.pwc.com/mn](http://www.pwc.com/mn)

Монгол Улсын Их Хурал 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийг ("АХШХТХ") баталсан бөгөөд тус хууль нь 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлснээр өмнөх 2001 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийг хүчингүй болсонд тооцно.

Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын "Хөдөлмөр эрхлэлтийн хувийн албадын тухай" 181 дүгээр Конвенцын үзэл баримтлалд нийцүүлэн Монгол Улсын иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг шинэчилсэн байна. Бид АХШХТХ-ийн гол онцлог зохицуулалтуудыг энэхүү мэдээллээрээ онцолж байна.



### Хуулийн зорилт, үйлчлэх хүрээ

АХШХТХ нь дараах харилцаанд үйлчилнэ:

- Монгол Улсын иргэн гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажих, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон харилцаа;
- гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөлтэй холбогдсон харилцаа.

Монгол улсад хөдөлмөр эрхлэх визээр ажиллаж байгаа гадаадын иргэд АХШХТХ-д заасан хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авах шаардлагатай.

- АХШХТХ-д гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээтэй холбоотой үүссэн хөдөлмөрийн харилцааг **Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна** гэж тодорхой заасан.
- Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл бүхий гадаадын иргэнд олгох виз, оршин суух зөвшөөрөлтэй холбогдсон харилцааг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.
- Хөдөлмөрийн зуучлах зөвшөөрөлтэй холбогдсон харилцааг энэ хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.



### Шинээр томъёолсон нэр томъёо, тодорхойлолт

#### 1. Гадаад ажилтан гэж хэн бэ?

- Монгол Улсад хөдөлмөр эрхэлж, эсхүл дадлагажиж байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн.

#### 2. Зуучлагч гэж хэн вэ?


- зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, ашгийн төлөө хуулийн этгээд.

#### 3. Зуучлах үйлчилгээ гэж юу вэ?


- Монгол Улсын иргэнийг гадаадад, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ.

#### 4. Зуучлуулагч гэж хэн вэ?

- зуучлах үйлчилгээ авч байгаа 18 насанд хүрсэн, Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн.



Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ээс бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.



## Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны ажлын байрны төрлийг удирдах, гүйцэтгэх, туслах байхаар анх удаа зохицуулав

□ Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны ажлын байр удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн төрөлтэй байна.



### Удирдах албан тушаал

1. гадаадын хөрөнгө оруулалттай компанийн ерөнхий захирал, гүйцэтгэх захирал, гадаадын хөрөнгө оруулагч, гадаадын хөрөнгө оруулагчийн төлөөлөгч;
2. аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал;
3. олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын удирдах ажилтан.



### Гүйцэтгэх албан тушаал

4. олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын ажилтан, сайн дурын ажилтан;
5. Засгийн газар, төрийн байгууллага хоорондын гэрээний дагуу шинжлэх ухаан, боловсрол, эрүүл мэнд, соёл, спортын салбарын байгууллагад ажиллах мэргэжилтэн;
6. Монгол Улсын Засгийн газраас тогтоосон нарийн мэргэшлийн мэргэжилтэн;
7. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эмнэлгийн мэргэжилтэн;
8. хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын гэрээнд тусгайлан заасны дагуу зөвхөн тухайн гэрээний хугацаанд гадаад улсаас Монгол Улсад ажиллах нарийн мэргэшлийн инженер, түүнтэй дүйцэхүйц ажилтан;
9. бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллагын ажилтан, бүх шатны боловсролын байгууллагад ажиллах багш;
10. соёл, спортын байгууллагад ажиллах мэргэжлийн багш, дасгалжуулагч, мэргэжилтэн.



### Туслах албан тушаал

11. ур чадвар бүхий мэргэшсэн техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшсэнийг нотлох тухайн улсын эрх бүхий байгууллагын, эсхүл Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдөх гэрчилгээ, диплом, мэргэжлийн үнэмлэхтэй ажилтан;
12. Монгол Улсад 6 сар хүртэл хугацаагаар ажиллах улирлын ажилтан.



## Гадаад ажилтныг хөдөлмөр эрхлүүлэхээр урих

- Удирдах болон гүйцэтгэх албан тушаалын **1-8 дугаартай** ажлын байранд ажиллуулах гадаад ажилтны хувьд, ажил олгогч нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар ("**Хөдөлмөр, халамжийн газар**")-с гадаад ажилтныг хөдөлмөр эрхлүүлэх урилга хүсэх эрхтэй.
- Гүйцэтгэх болон туслах албан тушаалын **9-12 дугаартай** ажлын байранд ажиллуулах гадаад ажилтны хувьд, тухайн ажлын байрны зарыг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн санд байршуулж, ажилтныг идэвхтэй хайж эхэлснээс хойш **ажлын 14 өдөр** өнгөрөхөд дотоодоос ажилтан авч чадаагүй тохиолдолд л гадаад ажилтныг хөдөлмөр эрхлүүлэх урилга хүсэх эрхтэй.
- Гадаад ажилтныг урих зөвшөөрөл нь ажил олгогч тухайн зарласан ажлын байранд гадаад ажилтныг хөдөлмөр эрхлүүлэх боломжтойг илэрхийлнэ.
- Татгалзаж үндэслэлгүй тохиолдолд Хөдөлмөр, халамжийн газар ажил олгогчид гадаад ажилтан урих зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар олгоно. Уг хугацааг АХШХТХ-д заасан нөхцөлийн дагуу **нэг удаа 3 хүртэл сараар** сунгаж болно.
- Хөдөлмөр, халамжийн газар **цахим систем** ашиглан гадаадын иргэнийг хөдөлмөр эрхлэхэд урих зөвшөөрөл, гадаад ажилтныг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөлтэй холбоотой үйлчилгээг үзүүлж болно.




## Гадаад ажилтныг хөдөлмөр эрхлүүлэхээр урих зөвшөөрлийг хязгаарлах

Хөдөлмөр, халамжийн газар дараах ажил олгогчийн гадаад ажилтныг урих эрхийг **2 жилийн** хугацаанд хязгаарлана:

- Ажил олгогч нь Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлгүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлсэн;
- Ажил олгогч нь өмнө нь хөдөлмөр эрхлүүлж байсан гадаад ажилтны цалин хөлсийг олгоогүй, эсхүл хохирол учруулсан нь тогтоогдсон;
- Ажил олгогч нь АХШХТХ-д заасны дагуу бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургаагүй;
- Ажил олгогч нь гадаад улсаас ажилтан авах зорилгоор тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжил, ур чадварыг хэт өндөр тавьсан эсхүл ажлын байрны шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг хөдөлмөр эрхлүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан;
- Ажил олгогч нь хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн санд ажлын байрны зарыг байршуулснаас хойш ажлын 14 өдрийн дараа гадаад ажилтныг хөдөлмөр эрхлүүлэх урилга хүсэх үүргээ биелүүлээгүй;
- Ажил олгогч нь АХШХТХ-д заасан тайлан мэдээг хуурамчаар гаргасан нь тогтоогдсон;
- Ажил олгогч нь гадаадын иргэнийг хууль тогтоомжид заасны дагуу холбогдох байгууллагад бүртгүүлээгүй, Монгол улсын виз, оршин суух зөвшөөрлийнх нь хугацаанд гадаадын иргэнийг буцаах үүргээ биелүүлээгүй нь тогтоогдсон;
- Ажил олгогчийн гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөл нь АХШХТХ-д заасан үндэслэлээр цуцлагдсан.





## Гадаад ажилтны Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл

- ✓ **Гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох:** гадаад ажилтан урих зөвшөөрөл авсан ажил олгогч гадаад ажилтны өмнөөс Хөдөлмөр, халамжийн газарт хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргана. Тус байгууллага гадаад ажилтанд **хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл** олгох ба хугацаа нь ажлын байр, хөдөлмөрийн гэрээний хугацаанаас хамааран **1 жил хүртэл** байна. Гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээний журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална.
- ✓ **Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл:** гадаад ажилтны овог, нэр, иргэний харьяалал, хөдөлмөр эрхлүүлэх хуулийн этгээдийн нэр, хөдөлмөр эрхлэх байршил, зөвшөөрлийн хугацаа зэрэг мэдээллийг агуулсан байна.
- ✓ **Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгах:** Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг холбогдох журмын дагуу сунгаж болно. Туслах албан тушаал эрхэлдэг гадаад ажилтны Монгол Улсад тасралтгүй хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн **нийт хугацаа 5 жилээс илүүгүй** байна.



## Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох

Хөдөлмөр, халамжийн газар гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

- ❑ гадаад ажилтны буруугаас хөдөлмөрийн гэрээг цуцалсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон, эсхүл хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон бол;
- ❑ эрүүл мэндийн үзлэг, шинжилгээгээр тухайн ажлыг гүйцэтгэхэд эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй болсон нь тогтоогдсон бол;
- ❑ гадаад ажилтан ажлын байраа дур мэдэн орхисон бол;
- ❑ Хөдөлмөр, халамжийн газрын зөвшөөрөлгүйгээр өөр ажил олгогчид шилжиж ажилласан бол;
- ❑ гадаад ажилтны мэдээллийн санд хуурамч баримт бичгээр бүртгүүлсэн бол;
- ❑ гэмт хэрэг, зөрчил үйлдэж гэм буруутай болох нь тогтоогдсон бол;
- ❑ гадаад ажилтан хөдөлмөрийн чадвараа алдсан бол.



АХШХтХ-д ажил олгогчийн **гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрлийг цуцлах үндэслэлүүдийг заасан 4 тус зөвшөөрлийг авахад шаардагдах бүрдүүлэх баримт бичиг, хугацаа зэрэг гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөл авахтай холбоотой зохицуулалтыг тусгаагүй** байна. Түүнчлэн, энэхүү зөвшөөрөл нь гадаад ажилтныг хөдөлмөр эрхлүүлэхээр урих зөвшөөрлөөс хэрхэн ялгаатай болох нь тодорхойгүй байна.




## Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

**Хөдөлмөр, халамжийн газар:** гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн нөхцөл, АХШХтХ-ийн хэрэгжилтэд жилд 1-ээс доошгүй удаа хяналт шалгалт хийх, гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид зөвлөгөө өгнө.

**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам:** зөвлөгөө өгөх, хамтарсан хяналт шалгалт хийх удирдамж, чиглэлийг баталж, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, холбогдох байгууллагад мэдэгдэх арга хэмжээг авна.

**Төрийн бус байгууллага:** тодорхой үйл ажиллагааны хүрээнд АХШХтХ-ийн хэрэгжилтэд олон нийтийн хөндлөнгийн хяналт тавьж болно. Хөдөлмөр, халамжийн газар хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх хүсэлт гаргасан төрийн бус байгууллагыг бүртгэж, хамтран ажиллана.



Дээр дурдсан хуулийн гол шаардлагууд, хууль зөрчихтэй холбоотой эрсдэлүүд болон АХШХтХ-тай холбоотой аливаа бусад асуултуудын талаар илүү дэлгэрэнгүй ярилцахыг хүсвэл бидэнтэй холбоо барина уу.

Дараах линкээр орж Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуультай танилцана уу. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390388880621>



## [pwc.com/mn](https://pwc.com/mn)

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүперс Легал ХХН-ээс бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2022 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсуотэрхаусКүүперс Легал ХХН -г илэрхийлнэ.